


Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны
01 сарын 30-ны өдрийн 15/01 тоот
тогтоолын хавсралт



ҮНЭТ ЦААС ГАРГАГЧААС МЭДЭЭЛЛИЙГ НИЙТЭД ТОГТМОЛ ХҮРГЭХ ТУХАЙ ДОТООД ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү мэдээллийн үйл ажиллагааны журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 505 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журманд нийцүүлэн хувьцаа эзэмшигчид болон оролцогч бусад этгээдэд АПУ ХК (цаашид “Компани” гэх)-ийн талаарх үнэн зөв мэдээллийг тогтмол хүргэх, Компани нь хууль тогтоомж, дүрэм журамд заасан болон бусад чухал ач холбогдол бүхий мэдээллийг нээлттэй болгох, хувьцаа эзэмшигчдийн зүгээс Компанийг удирдах үйл ажиллагаанд оролцох эрхээ зохистойгоор хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд оршино.
- 1.2 Журмыг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-өөс батлан гаргасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрднө.
- 1.3 Мэдээллийн нээлттэй ил тод байдлыг хангах журамд дараах зарчмыг мөрдлөг болгоно. Үүнд:
 - 1.3.1 Тухайн мэдээллийн ач холбогдол, Компанийн бизнест нөлөөлөх байдлаас хамааруулан мэдээллийг тогтмол давтамжтай боловсруулах, шинэчлэх;
 - 1.3.2 Хууль тогтоомж, дүрэм журамд заасан болон мэдээллийг нийтэд хүргэх шаардлага, ач холбогдолтой нь уялдуулан тогтсон цаг хугацаанд нь олон нийт, холбогдох эрх бүхий байгууллагад хүргэх;
 - 1.3.3 Компанийн хувьцаа эзэмшигчид болон оролцогч бусад этгээдэд тэгш хүртээмжтэй байх;
 - 1.3.4 Үнэн зөв, тодорхой, ойлгомжтой, бүрэн хэмжээтэй байх;
 - 1.3.5 Компанийн бизнесийн эрх ашиг, нээлттэй байх зарчим хоёрын зохистой тэнцвэрийг хангасан байх.



Хоёр. Мэдээлэл, түүний ангилал зориулалт

2.1 Компаниас боловсруулан гаргаж буй мэдээлэлд компанийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл, санхүүгийн тайлан болон хөрөнгө оруулагчид эсвэл оролцогч бусад этгээд мэдвэл зохих бусад мэдээллүүд багтана.

2.2 Компаниас боловсруулан гаргаж буй мэдээллүүдийг түүний зориулалт, нууцлалын шаардлага зэргийг харгалзан дараах үндсэн ангилалд хуваана. Үүнд:

2.2.1 Олон нийтэд нээлттэй түгээх мэдээлэл (1 дүгээр зэрэглэл);

2.2.2 Олон нийтэд зөвшөөрөлтэйгээр түгээх мэдээлэл (2 дугаар зэрэглэл);

2.2.3 Нууц мэдээлэл (3 дүгээр зэрэглэл).

2.3 **Олон нийтэд нээлттэй түгээх мэдээлэлд** Монгол Улсын зохих хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрээр олон нийтэд тараахыг үүрэг болгосон Компанийн хагас жилийн болон жилийн үйл ажиллагааны тайлан зэрэг мэдээлэлүүд буюу дараах мэдээллүүд багтана. Үүнд:

2.3.1. Үнэт цаас гаргагч буюу Компанийн зорилго, үйл ажиллагааны стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл;

2.3.2. Компанийн эрхэлж буй үйл ажиллагааны салбарт эзэлж буй байр суурь;

2.3.3. Компанийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбогдон үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл;

2.3.4. Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын талаарх мэдээлэл;

2.3.5. Компанийн хагас жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ;

2.3.6. Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл;

2.3.7. Компанийн Гүйцэтгэх удирдлагын хийж гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээлэл;


2.3.8. Компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл;

2.3.9. Компанийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт;

АПУ ХК-ийн
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛ**
ЭХ ХУВЬ


- 2.3.10. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр;
- 2.3.11. Компанийн ТУЗ-өөс гаргасан үнэт цаасны ханшид нөлөөлөх магадлалтай аливаа шийдвэр;
- 2.3.12. Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл;
- 2.3.13. Жилийн эцсийн үйл ажилагааны тайланд Компанийн удирдлага, холбогдох эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ, тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны талаарх мэдээлэл;
- 2.3.14. Аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан, түүний тайлбар тодруулга, дүгнэлт;
- 2.3.15. Тухайн жилийн санхүүгийн тайлангаар Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ болон хувь нийлүүлсэн хөрөнгийн харьцаа;
- 2.3.16. Компанийн хуваарилахаар шийдвэрлэсэн болон хуваарилсан ногдол ашгийн талаарх мэдээлэл;
- 2.3.17. Компанийн ногдол ашгийн бодлого;
- 2.3.18. Жилийн туршид авсан зээлийн жагсаалт, түүний эргэн төлөлтийн мэдээлэл;
- 2.3.19. Бусад компанийн хувьцааны хяналтын багц болон түүнээс дээш хувийг эзэмшдэг талаарх мэдээлэл;
- 2.3.20. Тайлант хугацаанд Компанийн үйл ажиллагаанд гарсан томоохон үйл явдлын талаарх мэдээлэл;
- 2.3.21. ТУЗ, дэд хороодын үйл ажиллагааны тайлан;
- 2.3.22. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан;
- 2.3.23. Монголын компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлсэн талаарх тайлан, хэрэв кодексын тодорхой заалтыг мөрдөөгүй бол түүний шалтгаан, тайлбар, хэзээ мөрдөж эхлэх хугацаа;
- 2.3.24. Хорооноос баталсан Үнэт цаас гаргагчаас нийтэд тогтмол хүргэх тухай журамд тухай бүр нээлттэй болгохоор заасан мэдээллийг нэгтгэсэн товчоо;

2.4 Олон нийтэд зөвшөөрөлтэйгээр түгээх мэдээлэлд Монгол Улсын зохих хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрээр олон нийтэд түгээхээр тогтсон, хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдад үндэслэл бүхий шийдвэр гаргахад шаардлагатай, үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал, эдийн засгийн үзүүлэлт, өмч




хөрөнгийн болон удирдлагын бүтэц, зохион байгуулалттай холбоотой мэдээллийг ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр олон нийтэд хүргэх нь зүйтэй хэмээн үзсэн компанийн үйл ажиллагаа, хувьцааны үнэ ханшид нөлөөлөх боломжтой мэдээллүүд орно. Үүнд:

- 2.4.1 Компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлдээ зогссон;
- 2.4.2 Компани үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлэх, хувьцааны ханшид нөлөөлөхүйц шинэ бүтээгдэхүүн зах зээлд танилцуулах;
- 2.4.3 Үндсэн болон шинэ бүтээгдэхүүнд зориулан тусгай зөвшөөрөл, патент, үйл ажиллагаа явуулах эрх, барааны тэмдэг эзэмших болон цуцлагдах;
- 2.4.4 Компанийн оноосон нэр, үндсэн захиргаа болон толгой компанийн оршин байх хаяг байршил өөрчлөгдсөн тухай мэдээлэл;
- 2.4.5 Компани салбар, төлөөлөгчийн газар байгуулах, татан буулгах тухай мэдээлэл;
- 2.4.6 Компанийн төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагад орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл;
- 2.4.7 Нийт ажиллагсадын 15 болон түүнээс дээш хувьд өөрчлөлт орох буюу чөлөөлөгдөх, шилжих, шинээр ажилд орох;
- 2.4.8 Бусад компанийн хувьцааны хяналтын багц болон түүнээс дээш хувийг худалдах, худалдан авах;
- 2.4.9 Компанийн хөрөнгө, өр төлбөр, хувьцаат капитал болон үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх гэрээ хэлцэл байгуулах;
- 2.4.10 Компанийн борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувьд нөлөөлөх бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай байгуулсан гэрээ хэлцлийг цуцлах, дуусгавар болох;
- 2.4.11 Компанийн борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувийг эзэлдэг үйл ажиллагаатай холбогдох аливаа тусгай зөвшөөрөл /лиценз/ эзэмших болсон эсхүл түүнийг хүчингүй болгосон, барьцаалсан, аливаа хэлбэрээр бусад шилжүүлсэн тухай мэдээлэл;
- 2.4.12 Компанийн үл хөдлөх хөрөнгийн үнийн дүнгийн 10 ба түүнээс дээш хувьтай



- тэнцэх хөрөнгийг худалдах, барьцаалах болон бусад хэлбэрээр бусдад шилжүүлэх, битүүмжлэх, тусгаарлах;
- 2.4.13 Компанийн хөндлөнгийн аудиторын байгууллагатай байгуулсан гэрээ, түүнд орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл;
- 2.4.14 Компанийн бизнесийн үйл ажиллагааны зарим хэсгийг охин, хараат компанид болон бусад этгээдэд шилжүүлэх болон хязгаарлах;
- 2.4.15 Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийсэн тухай мэдээлэл;
- 2.4.16 Компанийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой хувь хүн, хуулийн этгээдийн нэр /тэдгээр этгээд нь Компанийн хувьцааг эзэмшиж байгаа бол/;
- 2.4.17 Компанийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд өөрчлөгдсөн тухай мэдээлэл;
- 2.4.18 Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн бүтэц, түүний бусад компанид эзэмшиж байгаа хувьцаанд өөрчлөлт орох;
- 2.4.19 Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн өөрчлөгдөх;
- 2.4.20 Компанийн өрийг хувьцаагаар солих шийдвэр;
- 2.4.21 Хувьцааны опцион болон хувьцаа эзэмшигч үнэт цаас гаргагчийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрх бүхий нэмэлт хувьцаа гаргах шийдвэр;
- 2.4.22 Компанийг өөрчлөн байгуулах шийдвэр;
- 2.4.23 Компанийн хувьцааг хуваах, нэгтгэх шийдвэр;
- 2.4.24 Компани өр төлбөрөө эргэн төлөх санхүүгийн чадваргүй болох;
- 2.4.25 Компанийн охин болон хараат компани өр төлбөрөө төлөх санхүүгийн чадваргүй болох;
- 2.4.26 Компанийг татан буулгах шийдвэр;
- 2.4.27 Компанийн нийт гаргасан хувьцааны хяналтын багц эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, болон бусад эрх бүхий албан тушаалтнуудад холбогдох болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой гэмт үйлдэл хийсэн нь тогтоогдсон;
- 2.4.28 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр;
- 2.4.29 Компанийн ТУЗ-өөс гаргасан үнэт цаасны ханшид нөлөөлөх аливаа шийдвэр;



2.4.30 Бусад мэдээлэл.


- 2.5 Энэхүү журмын 2.4-т заасан мэдээллийг олон нийтэд тараах хугацаа, арга замыг компанийн ТУЗ тогтоох ба Гүйцэтгэх удирдлагын эрх мэдлийн хүрээнд мэдээллэх мэдээллүүдийг Гүйцэтгэх захирлын зөвшөөрөлтэйгээр нийтэд мэдээллэнэ.
- 2.6 Компанийн Нууцын тухай журамд заасан Байгууллагын болон Хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалагдсан мэдээллийг Нууц мэдээлэл гэх ба тус мэдээллийг шүүх, цагдаа, татвар зэрэг төрийн эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд мэдээлэхгүй.

Гурав. Мэдээллийг боловсруулах журам

- 3.1 Олон нийтэд нээлттэй ба зөвшөөрөлтэй түгээх мэдээллийг ТУЗ болон Компанийн тухайн асуудлаар харьяалсан чиг үүрэг бүхий албан тушаалтан, алба, нэгж, хэсгийн дарга хариуцан гаргаж Гүйцэтгэх удирдлагад болон Гүйцэтгэх удирдлагын томилсон мэдээллийг нийтэд түгээх эрх бүхий албан тушаалтанд шуурхай хүргэнэ.
- 3.2 Мэдээллийн үнэн бодит байдлыг мэдээлэл гаргасан алба нэгж хэсгийн дарга болон Гүйцэтгэх удирдлага, Гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон мэдээллийг түгээх эрх бүхий ажилтан хариуцах бөгөөд Компанийн Дотоод хяналт хариуцсан алба, ТУЗ-ын дэргэдэх Аудитын хороо хяналт тавина.
- 3.3 Компанийн ТУЗ-ын Нарийн бичгийн дарга, Үнэт цаас хариуцсан мэргэжилтэн нь энэхүү журмын 2-р хэсэгт заасан мэдээллүүдийг тухай бүр холбогдох эрх бүхий байгууллагад болон өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд түгээх үйл ажиллагааг зохион байгуулана.
- 3.4 Мэдээллэл боловсруулагч болон олж авсан ажилтан, хувь хүн нь мэдээллийг энэхүү журамд заасан нөхцөл, хугацаагаар нийтэд мэдээллэх хүртэл мэдээллийн нууцлалыг хариуцан ажиллах үүрэгтэй.

Дөрөв. Мэдээллийг түгээх хэрэгсэл, хугацаа

- 4.1 Мэдээллийг холбогдох алба буюу албадын хамтын ажиллагааны үндсэн дээр үнэн зөв эх сурвалжуудыг ашиглан боловсруулах ба компанийн цахим хуудас, Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн бирж, эрх бүхий байгууллагын цахим хуудас, холбоо харилцааны хэрэгслүүд, биечилсэн уулзалт, олон нийтийн мэдээллийн



сүвгуудын нэгийг буюу хэсгийг ашиглан хөрөнгө оруулагчид болон олон нийтэд хүргэнэ.

4.2 Компани нь Хагас жилийн үйл ажиллагааны тайлангаа жил бүрийн 08 дугаар сарын 01-ны дотор өөрийн цахим хуудсанд болон Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд түгээнэ.

4.3 Компанийн Хагас жилийн санхүүгийн тайлан нь энэхүү журмын 2.3.1-2.3.12 дугаар зүйлд заасан мэдээллийг агуулсан байна.

4.4 Компанийн Жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн дотор өөрийн цахим хуудсанд болон Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд түгээнэ.

4.5 Компанийн Жилийн эцсийн санхүүгийн тайлан нь энэхүү журмын 2.3.1-2.3.24 дүгээр зүйлд заасан мэдээллийг агуулсан байна.

4.6 Энэхүү журмын 2.4.1-2.4.30 дугаар зүйлд заасан тухай бүр нээлттэй болгох, Олон нийтэд зөвшөөрөлтэйгээр түгээх мэдээлэлд дээр дурдсан аливаа үйл явдал, өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухайн үйл явдал өөрчлөлт болсоноос хойш ажлын 2 өдөрт багтаан өөрийн болон Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээллэнэ.

4.7 Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд огцом өөрчлөлт гарсан тохиолдолд дараах арга хэмжээг авна. Үүнд:

4.7.1 Энэхүү журмын 2.4.1-2.4.30 дугаар зүйлд заасан өөрчлөлтийн талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гарч буй мэдээлэл нь тухайн үнэт цаас гаргагчийн үнэт цаасны ханшид мэдэгдэхүйц нөлөөлөхөөр бол энэ талаар судалж, холбогдох үндэслэл бүхий тайлбарыг Монголын хөрөнгийн биржид хуанлийн 3 өдөрт мэдэгдэнэ.

4.7.2 Компанийн удирдлага тухайн огцом өөрчлөлт нь үнэт цаас гаргагчийн үнэт цаасны ханшид сөргөөр нөлөөлнө гэж үзвэл энэ талаар олон нийтэд ажлын 1 өдөрт багтаан мэдээлнэ.

4.8 Хэрэв Компанийн охин болон хараат компанийн үйл ажиллагаанд гарсан аливаа өөрчлөлт нь үнэт цаас гаргагчийн үнэт цаасны ханшид мэдэгдэхүйц нөлөөлөхөөр бол энэ талаар нийтэд хуанлийн 2 хоногт мэдээлэх үүрэгтэй.

4.9 Олон нийтэд нээлттэй түгээх мэдээллүүдийг компанийн цахим хуудсанд

АПУ ХК-ийн
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЭХ ХУВЬ

байрлуулсан хугацаанаас хойш 5 жил хадгалагдах боломжтойгоор программ хангамжийг тохируулсан байна.

4.10 Олон нийтэд нээлттэй түгээсэн мэдээллүүдийн эх хувь, цаасан болон цахим баримтуудыг Компанийн Архив албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу бүртгэж хадгалана.

Тав. Дотоод мэдээлэл эзэмшигч, түүний арилжаанд оролцох журам

5.1 Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 76 дугаар зүйлд зааснаар үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх нийтийн хүртээл болоогүй мэдээллийг дотоод мэдээлэл гэх ба нийтэд нээлттэй мэдээлэлд үндэслэн хийсэн дүн шинжилгээ нь үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлөх боломжтой байсан ч түүнийг дотоод мэдээлэл гэж үзэхгүй.

5.2 Дараах этгээдийг Компанийн дотоод мэдээлэл эзэмшигч гэж үзнэ:

5.1.1 Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, ажилтан болон тэдгээрийн холбогдох этгээд буюу Хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал болон үйл ажиллагаа хариуцсан захирлууд, алба газрын дарга нар

5.1.2 Албан үүргээ хэрэгжүүлэх, гэрээ, хэлцлийн бэлтгэл болон түүнийг байгуулах, гүйцэтгэх үе шатанд дотоод мэдээллийг олж авсан этгээд болон тэдгээрийн холбогдох этгээд буюу алба газруудын ахлах мэргэжилтэн, нягтлан бодогч, ахлах менежерүүдийг ойлгоно.


5.3 Энэхүү журмын 4.2-т заасан дотоод мэдээлэл эзэмшигчидэд дараах зүйлийг хориглоно. Үүнд:

5.3.1 Уг мэдээллийн улмаас ханш, арилжааны хэмжээ нь хэлбэлзэх үнэт цаас болон түүнд суурилсан санхүүгийн хэрэгслийн арилжаанд оролцох;

5.3.2 Уг мэдээллийг дотоод мэдээлэл гэдгийг мэдсэн эсэхээс үл хамааран ханш, арилжааны хэмжээ нь хэлбэлзэх үнэт цаас, түүнд суурилсан санхүүгийн хэрэгслийн арилжаанд оролцохыг бусдад санал болгох, ятгах;

5.3.3 Албан тушаал, ажил үүргийн хувьд мэдээллийг нээлттэй болгох үүрэг хүлээснээс бусад тохиолдолд бусдад дотоод мэдээллийг задруулах


Зургаа. Хариуцлага



6.1 Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгүүлэхээр Төрийн эрх бүхий байгууллагад асуудлыг тавина.


6.2 Журмыг зөрчсөн холбогдох ажилтны үйлдэлд эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэхээргүй бол Компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу хөдөлмөрийн сахилгын арга хэмжээ ногдуулана.

6.3 Журмыг зөрчсөн ажилтны үйлдэл нь Компанийн эд хөрөнгөд хохирол учруулсан бол түүнд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан үсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэж болно.



oooOooo

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны
01 сарын 30-ны өдрийн 45/04 тоот
тогтоолын хавсралт



Компанийн цахин хуудсанд мэдээлэл тавих загвар

Дэд цэсний нэр: Хувьцаа эзэмшигчдэд зориулсан мэдээлэл

Дэд цэсэнд агуулагдах мэдээллийн төрөл:

1. **Танилцуулга:** Компанийн үйл ажиллагааны чиглэл, стратеги, зах зээлд эзлэх байр суурийн талаар товч танилцуулга
2. **Мэдээлэл:** Хувьцааны үнэ ханшинд нөлөөлж болох компанийн засаглал үйл ажиллагааны өөрчлөлт, үйл явдлын талаарх цаг үеийн мэдээлэл, удирдлагын бүтэц бүрэлдэхүүний өөрчлөлт гм мэдээллийг хүргэнэ
3. **Санхүүгийн мэдээлэл:** Хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайлан, түүнд хийсэн дүн шинжилгээ, жилийн эцсийн аудтын тайлан дүгнэлт, зээлийн жагсаалт,
4. **Хувьцаа эзэмшигчид:** Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн хувь эзэмшлийн мэдээлэл, түүний өөрчлөлтийг хүргэнэ
5. **Хувьцаа эзэмшигчдийн хурал:** Хурал хуралдах болон хурлаас гарсан шийдвэрүүдийн талаар мэдээллэнэ.
6. **Ногдол ашиг:** Ногдол ашгийн бодлого, ногдол ашиг тарааж байсан мэдээлэл, ногдол ашиг тараах тухай шийдвэр
7. **ТУЗ:** ТУЗ-ын гишүүд, хороод, үйл ажиллагааны тайлан, үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх аливаа шийдвэрүүдийг түгээнэ
8. **Гүйцэтгэх удирдагч:** Гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтануудын мэдээлэл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан

